

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 оны.01 дүгээр сарын 5-ны өдөр.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахв хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийг хамт олны санал асуулгаар сонгож, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/56 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан.

2025 онд Ёс зүйн дэд хорооны дарга болон гишүүдээр ажиллаж байсан албан хаагчид өөр ажилд шилжих, өндөр насны тэтгэвэрт гарсантай холбогдуулан яамны албан хаагчдаас 2 удаагийн санал асуулгаар гишүүдээ нөхөн сонгож томилсон. Ёс зүйн дэд хорооны 1 гишүүн 2025 оны 12 дугаар сараас өөр ажилд шилжиж, одоогоор 6 гишүүнтэй ажиллаж байна.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, Ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт, тайлан мэдээ гаргах үндсэн чиг үүргийн хүрээнд нийт 15 үйл ажиллагааг олонхын саналаар баталсан.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 91.0 хувийн хэрэгжилттэй байна.

Эрүүл мэндийн яамны Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдэж байгаатай холбогдуулан ёс зүйн зөрчлийн хэлбэрүүдийг дурдаж оруулах, ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд хийгдэх зохицуулалт, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх тухай бүлэг нэмэлтээр оруулах санаачилга гаргаж, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх тухай бүлэг, ажилтан хоорондын харилцаа (ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамт гэх мэт)-ны хүрээнд 2025 оны 04 дүгээр сард санал өгсөн болно.

Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд <https://moh.gov.mn/p/180> Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй байршуулж, тухай бүр шинэчилж байна.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос харьяа агентлаг, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон бусад эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд чиглэл өгч, мэргэжил арга зүй, мэдээллээр ханган ажиллаж байна. 2025 оны 12 дугаар сарын байдлаар Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Хавдар судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн төв сувилал, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв зэрэг 14 байгууллага Ёс зүйн дэд хороо байгуулан ажиллаж байна.

Хоёр. Зохион байгуулсан Ёс зүйн дэд хорооны хуралдаан, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах талаар

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 2025 онд нийт 10 удаа хуралдаж, 19 асуудал хэлэлцсэн.

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороонд 2025 онд нийт 21 өргөдөл, гомдол, хүсэлт ирснээс хугацаанд нь шийдвэрлэсэн 20, хугацаа хоцорсон, шийдвэрлээгүй байгаа 1 тус тус байна. Өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлт 2025 оны байдлаар 95.2 хувьтай байна. Дөрвөн албан хаагчид ёс зүйн зөрчил гаргаагүй талаар тодорхойлолтыг гаргаж өгсөн.

Гурав. Албан хаагчдыг ёс зүйн чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах

Байгууллагын соёлыг төлөвшүүлэн түгээн дэлгэрүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын ёс зүйн манлайллыг хөгжүүлэх замаар харилцан хүндэтгэлтэй, тэгш оролцоог хангасан ажлын эерэг орчин болгон бүрдүүлэх зорилгоор “Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд бидний оролцоо” сэдэвт нөлөөллийн аян зохион байгуулах удирдамжийг Дэд хорооны даргаар 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдөр батлуулж, харьяа эрүүл мэндийн байгууллагууд 2025.06.16-07.05-ны өдрүүдэд 14 хоногийн нөлөөллийн аян зохион байгуулсан.

Байгууллагын албан хаагчдад үнэт зүйлд суурилсан ёс зүйн манлайллыг бий болгох, байгууллагын соёлыг зөв төлөвшүүлэх, хувь хүний ёс зүйн зан үйлийг нэмэгдүүлэх чадвар олгох зорилгоор Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь яамны Төрийн захиргааны удирдлагын газартай хамтран 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр “Үнэт зүйлд суурилсан манлайлал: Байгууллагын соёл ба хувь хүний зан үйл” сэдэвт сургалтыг зохион байгуулж, яамны 63 албан хаагч оролцсон.



Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 оны 10 дугаар сард “Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчил: Иргэд болон төрийн албан хаагчдын

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал” батлагдсан. Төрийн 10 байгууллагыг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгосонд Эрүүл мэндийн яам орсон.

● Хүний эрхийн Үндэсний комисс	92
● Санхүүгийн зохицуулах хороо	81
● Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	71
● Эрүүл мэндийн яам	62
● СХД-ийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Ажлын алба	23
● Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар	35
● Төрийн худалдан авах ажиллагааны газар	53
● Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	91
● Багануур дүүргийн Шүүхийн тамгын газар	40
● Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	27

Төрийн албан хаагчийн ёс зүйн зорчилд ортох эрсдэлийг тооцох үнэлгээний нэгтгэл

[illegible]

Үйлэмний нэгтгэл дүнхэлт гаргасан. ЭМХ-ны дэргэдээ. Бс-гүйн эдд хороомыг нэрийн бичлэйд гарга С.Энхэм

	УМЕРЛАР	ГУРДОНЛАР	ТУСАЛАР	ЖАЙ
1-5	6	26	0	31
6-10	3	17	0	20
11-15	1	1	0	2
16	0	0	0	0

5	УМОНДАН ГҮЙНГЭГЭН ТУСЛАХ ИЙТ			
1-5	2	19	0	21
6-10	5	18	0	23
11-15	1	3	0	4
16-20	1	1	0	2

3

“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ”-ний үр дүнг танилцуулах, хэлэлцэх цахим уулзалтыг 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүд цахимаар идэвхтэй оролцсон.

Дөрөв. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад хамрагдах

Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах чиглэлээр 2025 онд нийт 17 гишүүн (давхардсан тоогоор) цахимаар болон танхимаар 6 удаагийн сургалтад хамрагдсан. Тухайлбал,

- Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах” сэдэвт цахим сургалтад Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 5 гишүүн;

- Удирдлагын академиас 2025 оны 03 дугаар сарын 11-12-ны өдөр зохион байгуулсан “Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах” сэдэвт сургалтад Ёс зүйн дэд хорооны 3 гишүүн;

- Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад 2025 оны 05 дугаар 21-23, 27-ны өдөр Ёс зүйн дэд хорооны 3 гишүүн;

- Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 28-29-ний өдөр зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” нийслэлийн зөвлөгөөнд 3 гишүүн;

- Эрүүл мэндийн яам, ДЭМБ-аас 2025 оны 08 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан “Бэлгийн ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ” уулзалт, хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2 гишүүн;

- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын манлайлал, менежментийг сайжруулах, сахилга, хариуцлага, соёл, ёс зүйн хэм хэмжээг сахих чиглэлээр тулгамдсан асуудлыг хэлэлцэх, санал солилцох зорилгоор “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлага” үндэсний хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, нийт 150 гаруй хүмүүс оролцсон. Энэхүү хэлэлцүүлэгт ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны дарга болон нарийн бичгийн дарга оролцсон.

Тайлан хянасан:

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн
дэд хорооны дарга



С.Жаргалсайхан

Тайлан боловсруулсан:

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны
нарийн бичгийн дарга



С.Энхжин